



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/04

Баян-Овоо

Ахмад настанд хүндэтгэл үзүүлж
золгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2-р хавсралтын “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. XVII жарны “Элдэв эрдэнэт” хэмээх модон могой жилийн билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн-Цагаан сарын баярыг тохиолдуулан тус байгууллагын ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Төр, захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Хүндэтгэлийн 360,000 (Гурван зуун жаран мянга) төгрөгийг байгууллагын ахмадын сангийн зардлаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ГЭРЭЛМАА



020000088